

2020 ОНЫ 1-Р УЛИРЛЫН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“ЛэндМН ББСБ” ХК



Агуулга

Онцлох үйл явдлууд	04
Харилцагчийн үйлчилгээ	09
Зээлийн үйл ажиллагаа	13
Санхүүгийн үйл ажиллагаа	15
Компанийн засаглал	19

Гүйцэтгэх захирлын илгээлт



“

GLOBAL BANKING & FINANCE AWARDS® –аас 2020 оны Монголын Шилдэг Финтек компаниар ЛэндМН ББСБ ХК-ийг тодруулан өргөмжилсөн баярт мэдээг дуулгахад таатай байна.

”

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт хамтран ажиллагч байгууллагууд болон харилцагчид, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид ээ! Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна.

“ЛэндМН ББСБ” ХК нь нийт харилцагчид болон хувьцаа эзэмшигчид та бүхэндээ 2020 оны 1-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

Энэхүү тайландаа бид 2020 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд болон үндсэн тоон үзүүлэлтүүдийг танилцуулах бөгөөд “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд амжилтуудаа улам бататгаж, үйл ажиллагаагаа улам өргөжүүлсэн улирал болж өнгөрлөө.

Дэлхий даяар хурдацтай тархаж буй шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлэх үүднээс 2020 оны 3-р сарын 5-нд СЗХ-оос гаргасан уриалгыг “ЛэндМН ББСБ” ХК хүлээн авч технологийн шийдэл, цахим хэрэгслийг ашиглан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа LendMN фейсбүүк хуудсаар live байдлаар дамжуулан өнгөрөгч 2020 оны 03-р сарын 28-ны өдөр хувьцаат компаниуд дундаас хамгийн анх удаа “Цахим хэлбэр”-ээр амжилттай зохион байгуулсныг дуулгахад баяртай байна. Энэ нь Монгол улсын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн анх удаа цахим хэлбэрээр зохиогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал болж, түүх болон тэмдэглэгдэн үлдлээ.

Шинэ төрлийн коронавирустэй үеийн нөхцөл байдалд хэрхэн зөв ажиллаж амьдрах, бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн тогтвортой хэвийн явуулах вэ гэсэн асуултууд дэлхийн бүх улс орнуудад төдийгүй Монгол улсын хэмжээнд ч адилхан тулгамдсан асуудал болоод байна.

Цар тахал дэлхий нийт болон Монгол улсын хэмжээнд идэвхжсэн, санхүү эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсч магадгүй энэ цаг мөчид хэрэглэгчдээ бодсон арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ улиралд бид хэрэглэгчдийнхээ санхүүгийн байдалд учирч буй асуудлыг хамтран шийдвэрлэх зорилгоор 2020 оны 3 сарын 16-ны өдрөөс эхлэн LendMN аппликейшнээр зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжийг олгосноос гадна бонус оноогоо зарцуулж зээлийнхээ шимтгэлээ бууруулах боломжийг олгож, энэхүү эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд иргэд, харилцагчдадаа

санхүүгийн нэмэлт дарамт учрахаас хамгаалах үүднээс олгосон зээлд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд салбартаа ямагт тэргүүлэгч байр сууриа хадгалан технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээгээр харилцагчдынхаа бичил санхүүгийн асуудлыг шийдсээр ирсэн билээ.

Хэдийгээр 2020 оны эхний улиралд цар тахлын эрсдэлтэй нөхцөл байдлын улмаас дэлхий дахинаа эдийн засгийн хүндрэлтэй байдал үүссэн эерэг мэдээлэл ховор байсан ч “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд харилцагчиддаа дуулгах таатай мэдээтэй байна.

Дэлхийн хөрөнгийн зах зээл, банк санхүүгийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг бие даасан хараат бус байдлаар тэнцвэртэйгээр дэлхийн 200 гаруй улс оронд зэрэг нэгтгэн хүргэдэг Global Banking & Finance Review® байгууллагаас жил бүр орон орны банк, санхүүгийн оны шилдгүүдийг тодруулдаг бөгөөд Global Banking & Finance Awards® –аас Банк Бус Санхүүгийн салбарын төрөлд 2020 оны Монголын Шилдэг Финтек компаниар “ЛэндМН ББСБ” ХК-ийг тодруулан өргөмжилсөн баярт мэдээг дуулгахад таатай байна. Мөн 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр “ЛэндМН ББСБ” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг авсан болно.

Шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ болзошгүй эрсдэлээс өөрсдийгөө болон гэр бүл, хайртай хүмүүсээ хамгаалахын тулд тогтмол амны хаалтаа зүүж, гараа ариутгаж, өдөр тутмын эрүүл ахуйн энгийн дүрмүүдээ дадал, хэвшил болгож, дагаж мөрдөхийг дахин уриалж байна.

Эрүүл биед саруул ухаан гэдэг зүйр үг шиг эрүүл мэнд, эрүүл байх, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх нь Монголчууд бидний монгол иргэн хүн нэг бүрийн хамгийн эхний нэгдүгээрт тавигдах чухал асуудал учраас энэхүү эдийн засгийн болоод эрүүл мэндийн хүндрэлтэй нөхцөл байдлыг хамтдаа хариуцлагатайгаар даван туулах цаг мөч бидний өмнө ирээд байна.

Нийт харилцагч, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид та бүхэндээ эрүүл энхийг хүсье.

Хүндэтгэсэн:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал
О.Болдбаатар

2020.04.13

01

Онцлох үйл явдлууд





“The Voice of Mongolia” шоу нэвтрүүлгийн 2-р улирлын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаа.

"Авьяас, Чанар, Чадвар" гурвын төгс хослолоос бүрдэх “Зөвхөн шилдэг”-үүдийн өрсөлдөх үндэсний шилдэг дуучин шалгаруулах дэлхийн тайз! Мөрөөдөл биелдэг!

Голланд улсаас гаралтай “The Voice of Mongolia” шоу нь өдгөө дэлхийн 100 гаруй оронд амжилттай зохион байгуулагдсан дэлхийн хамгийн их үзэгчтэй шоу нэвтрүүлэг билээ.

Энэхүү "Авьяас, Чанар, Чадвар" гурвын төгс хослолоос бүрдэх “Зөвхөн шилдэг”-үүдийн өрсөлдөх үндэсний шилдэг дуучин шалгаруулах дэлхийн тайз “The Voice of Mongolia” шоу нэвтрүүлгийг 2018 онд “Монгол ТВ” телевиз Монголдоо нутагшуулж үзэгчдийн хүртээл болгосон.

Мөн “The Voice of Mongolia” шоу нь Монголоос анх удаа “Азийн телевизүүдийн наадам”-д нэр дэвшигдэж “Шилдэг нутагшуулсан контент”, “Шилдэг энтертэймэнт контент” гранпри шагналуудыг хүртэж бид бүгдийн бахархал болсон. Тэгвэл үзэгчдийн хүсэн хүлээж байсан The Voice of Mongolia шоуны 2-р улирлыг “Монгол ТВ” телевиз 2020 онд дахин зохион байгуулж дэлхий даяар COVID-19 вирусийн айдас дор байгаа энэ цаг үед, ард түмнийхээ сэтгэлийг дэмнэж, гэр бүлээрээ долоо хоногт бүр нэгэн оройг хамтдаа өнгөрүүлэх боломжийг олгосоор байна.

Телевизийн алдартай шоу нэвтрүүлэг болох “The Voice of Mongolia” нэвтрүүлгийг Монгол HD телевиз албан ёсны эрхтэйгээр эзэмшиж 2 дахь жилдээ зохион байгуулж байгаа билээ. “The Voice of Mongolia” шинэ улирлын дугаарт “ЛэндМН ББСБ” ХК болон “Анд Системс” ХХК хамтран ажиллаж байна.

Шилдэг дуу хоолойны төлөөх дэлхийн тайзнаа авьяаслаг залуус Монголын болоод дэлхийн шилдэг уран бүтээлүүдийг шинэ, содон, сонирхолтой хувилбараар хүргэж үзэгчдийн хайр хүндлэлийг хүлээн “Монголын шинэ дуу хоолой” гэх хүндтэй нэрийн эзэн болох юм.


“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал “Цахим хэлбэр”-ээр амжилттай зохион байгуулагдлаа.

Дэлхий даяар хурдацтай тархаж буй шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлэх үүднээс 2020 оны 3-р сарын 5-нд СЗХ-оос гаргасан уриалгыг “ЛэндМН ББСБ” ХК хүлээн авч технологийн шийдэл, цахим хэрэгслийг ашиглан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа ТУЗ-өөс гаргасан товын дагуу LendMN фейсбүүк хуудсаар live байдлаар дамжуулан, өнгөрөгч 2020 оны 03-р сарын 28-ны өдөр хувьцаат компаниуд дундаас хамгийн анх удаа “Цахим хэлбэр”-ээр амжилттай зохион байгууллаа.

Энэ нь Монгол улсын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн анх удаа цахим хэлбэрээр зохиогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал болж, түүх болон тэмдэглэгдэн үлдэж байна.

Хувьцаа эзэмшигчид тусгай вэб хуудсанд урьдчилан хүлээн авсан кодоор нэвтэрч хурлын ирцээ бүртгүүлж хэлэлцэх асуудлуудад саналаа өгсөн нь хүний оролцооноос шалтгаалсан алдаа гарахааргүй оновчтой шийдэл байлаа.

2019 онд 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласны үр дүнд хувьцаа эзэмшигчдэдээ 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн бөгөөд 2020 оны 4-р сарын 30-ны өдөрт багтан үнэт цаасны дансаар нь дамжуулан хуваарилахаар шийдвэрлэсэн билээ.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрүүд

“ЛэндМН ББСБ” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 80.75% нь оролцож, компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж баталлаа. Үүнд:

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч батлав.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн 5, хараат бус 3 гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 1 жилээр сунгаж, улируулан сонгохоор шийдвэрлэв.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүнээр Цэвэгжав овогтой Одмааг сонгохоор шийдвэрлэв.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлав.
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг дэмжин батлав.
- Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 5 тэрбум хүртэл төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх, холбогдох асуудлаар шийдвэр гаргах эрхийг Компанийн ТУЗ-д олгох саналыг батлав.

Global Banking & Finance Review Awards-аас "Шилдэг финтек" компаниар шалгарлаа.

Дэлхийн 200 гаруй оронд хөрөнгийн зах зээл болон банк санхүүгийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг хараат бус тэнцвэртэй байдлаар хүргэдэг "Global Banking & Finance Review" байгууллагаас жил бүр орон орны банк, санхүүгийн байгууллагуудын шилдгүүдийг тодруулдаг билээ.

Бидний үйл ажиллагааны амжилтыг батлан Монгол улсын Банк бус санхүүгийн салбарын 2020 оны "Шилдэг финтек" компаниар "ЛэндМН ББСБ" ХК-ийг тодрууллаа.

Тус байгууллага нь ЛэндМН ББСБ ХК-ийг шилдгээр өргөмжлөхдөө Монгол улсын банк бус санхүүгийн системд эзлэх байр суурь, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүлсэн шинэ шилдэг үйлчилгээ, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар нэр төрөл, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан LendMN аппликейшний зээлийн үйлчилгээний тэргүүлэгч байр суурь, харилцагчдын аппликейшний хэрэглээ, үйлчилгээний хурд, түргэн шуурхай байдал, идэвхтэй харилцагчийн тоо зэрэг үндсэн шалгуурыг үндэслэж дээрх нэр хүндтэй шагналыг олгосон байна.

Энэхүү шагнал нь эрхэм харилцагч, LendMN-ийн хэрэглэгч, хувьцаа эзэмшигчид, хамтран ажилладаг байгууллагууд та бүхний бидэнд итгэл хүлээлгэсэн хамтын шагнал юм.

LendMN аппликейшний нийт хэрэглэгч та бүхэндээ баярлалаа.

Эх сурвалж: <https://www.globalbankingandfinance.com/global-banking-fin.../>



NON-BANKING FINANCIAL
INSTITUTIONAL AWARDS



02

Харилцагчийн үйлчилгээ



Зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжийг олголоо.

Цар тахал буюу шинэ төрлийн Коронавирусын (Covid-19) халдварын улмаас Дэлхийн нийт болон Монгол Улсын хэмжээнд санхүү, эдийн засгийн хүндрэл учирч байгаатай холбогдуулан Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2020 он 3 сарын 17-ны өдөр гаргасан шийдвэр, Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 3 сарын 18-ны өдрийн мэдэгдэлд үндэслэн Монгол Улсын Засгийн газраас зарласан гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд “ЛэндМН ББСБ” ХК нь харилцагчдынхаа санхүүгийн байдалд учирч буй асуудлыг хамтран шийдвэрлэх зорилгоор тухайн цаг үеийн шийдвэрүүдэд тохируулан түргэн шуурхай ажилласан нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ боллоо.

Энэхүү эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд “ЛэндМН ББСБ” ХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд харилцагчдадаа санхүүгийн нэмэлт дарамт учрахаас хамгаалах үүднээс 2020 оны 3 сарын 16-ны өдрөөс эхлэн LendMN аппликейшнээр авсан зээлийнхээ эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжийг олгож сунгалтын товчийг нэмэлтээр шийдэж, тухай бүр LendMN фейсбүүк хуудсаар албан ёсоор мэдээлж ажиллалаа. Энэ нь зээлийн эргэн төлөлтийн хугацаагаа сунгах хялбар боломжийг харилцагчдадаа олгосон томоохон үйлчилгээ болсон бөгөөд цар тахлаас үүдэлтэйгээр эдийн засгийн уналттай энэ үед цаг үеэ олсон хэрэглэгчдийн зүгээс сайшаал дагуулсан үйл явдал боллоо.

Мөн харилцагчдад ирээдүйд үүсч болох санхүүгийн дарамтаас урьдчилан сэргийлэхийн тулд шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна.

LENDMN АППЛИКЕЙШНЭЭС АВСАН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨХ ХУГАЦААГ СУНГАХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

2020.04.30-ыг дуустал

ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ СУНГАХ БОЛОМЖУУД

ЗЭЭЛИЙН ТӨЛӨЛТИЙН ӨДРӨЭС ӨМНӨХ **5** ХОНОГ - ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦАА ХЭТЭРСНЭЭС ХОЙШ **5** ХОНОГ

ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦАА **15** ХҮРТЭЛ ХОНОГ ХЭТЭРСЭН БОЛ

ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦАА **15-с дээш** ХОНОГ ХЭТЭРСЭН БОЛ

Зээлийн эргэн төлөлтийн хугацааг LendMN аппликейшнээр сунгах боломжтой.

Сунгах

Зээлийн эргэн төлөлтийн хугацаагаа **7511-0101** дугаарт хандаж сунгах боломжтой.

ЗЭЭЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ ЗААВАР

- 01 LendMN аппликейшны нүүр хуудсанд байрлах “ЗЭЭЛТ” цэс рүү орно.
- 02 Хугацааг сунгахыг хүссэн зээлийн мэдээллийн “ДЭЛГЭРЭНГҮЙ” товчийг дарна.
- 03 Зээлийн мэдээлэлтэй танилцаад “СУНГАХ” товчийг дарна.
- 04 Уг зээлийг сунгах хугацаагаа сонгоод “ХУГАЦАА СУНГАХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ” товчийг дарна.
- 05 Ингэснээр таны сунгах зээлийн шимтгэлийн дүн харагдах ба талбар төлөх төрлөөс өөрт тохиромжтой сонгож “ТӨЛӨХ” товчийг дарна.

Танд Лэнд хэтэвчээ цэвэрлэж, хэтэвчнээсээ шимтгэлээ төлөх нь илүү хялбар болохыг сануулъя.

2020.04.30-ыг дуустал

ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГАА СУНГАХ ИЛҮҮ ХЯЛБАР БОЛЛОО

www.lend.mn 7707-0101

Бонус оноогоо ашиглан шимтгэлээ бууруулах боломжийг олголоо.

LendMN аппликейшны зээлийн харилцагчдадаа зориулан хуримтлагдсан бонус оноогоо ашиглаж одоо байгаа зээлийнхээ шимтгэлийг бууруулах боломжийг олгож эхэллээ.

LendMN аппликейшны үнэнч хэрэглэгчид одоо байгаа зээл бүрийнхээ шимтгэлийг 450 бонус оноогоор 10% бууруулах боломжийг туршилтаар олгож, цаашид ямар байдлаар хэрхэн хуримтлагдсан бонус оноогоо зарцуулж шимтгэлээ бууруулж болох талаар хэрэглэгчийн санал, судалгааны үр дүнд үндэслэн харилцагчдад тохирсон зээлийн бүтээгдэхүүн санал болгох тал дээр төвлөрч ажиллаж байна.

ХУРИМТЛАГДСАН БОНУС ОНООГОО ЗАРЦУУЛАХ ШИНЭ БОЛОМЖ

2020.03.31-ний 12:00 цаг хүртэл

450 оноогоор шимтгэл бууруулах

Баталгаажуулах

БОНУС ОНООГОО АШИГЛАН ЗЭЭЛИЙН ШИМТГЭЛЭЭ ХЭРХЭН БУУРУУЛАХ ВЭ?

01

LendMN аппликейшны **“Зээл”** цэс рүү орно.

02

Бонус оноо ашиглах товчийг идэвхжүүлж **“Баталгаажуулах”** товчийг дарна.

03

Бонус оноогоо ашиглах санамжийг зөвшөөрч **“Тийм”** товчийг дарна.

04

Та бонус оноогоо ашиглан амжилттай шимтгэлээ буурууллаа.

Харилцагчийн үйлчилгээний төв

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 33 ажилчидтайгаар LendMN аппликэйшний зээлийн үйлчилгээний талаарх хэрэглэгчдэд шаардлагатай тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж өгөх зорилготойгоор өдөр тутмын тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг бөгөөд 2020 оны 1-р улирлын турш нийт 203,197 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликэйшн ашиглалт болон бусад үйлчилгээний лавлагааг үзүүлж тэдгээрийн 99.77 %-д амжилттай үйлчлэн асуудлыг нь бүрэн шийдвэрлэсэн байна.

Шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ эрсдэлтэй байгаа энэ цаг үед харилцагчдаа болзошгүй эрсдэлээс сэргийлж, олон хүн цугларсан газраар явуулахаас зайлсхийж, цахим хэлбэрээр буюу LendMN фейсбүүк хуудсаар, contact@lend.mn цахим шуудангаар болон харилцагчийн үйлчилгээний 7707-0101 дугаарын утсаар болон 140101 дугаарт мессеж хүлээн авч утсаар мэдээлэл өгч ажиллалаа.



11 сек

Хүлээлгийн
түвшин

203'197

1-р улирлын
нийт дуудлага

99.77%

Амжилттай
үйлчилсэн



4'427

Сошиал сувгаар
үйлчилсэн /fb & mail/



6'695

Үйлчилгээний заалаар
үйлчилсэн

03

Зээлийн үйл ажиллагаа




Зээлийн үйл ажиллагаа

2020 оны 1-р улиралд нийт хэрэглэгчдэдээ 122.8 тэрбум төгрөгийн 527.0 мянган зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна.


Ингэснээр “ЛэндМН ББСБ” ХК-ийн харилцагчиддаа олгосон нийт зээлийн хэмжээ 705 тэрбум төгрөгт хүрч, нийт олгосон зээлийн тоо 3.3 сая болсон байна. Түүнчлэн нийт зээлийн гэрээтэй харилцагчдын тоо 5.1%-иар өсч 174.9 мянгад хүрсэн амжилттайгаар бид 2020 оны 1-р улирлаа үдлээ.

2020 оны 1-р улирлын тайлангийн үзүүлэлтүүдийг өмнөх оны тайлант үетэй харьцуулсан байдал


Гэрээт харилцагчид, өссөн дүнгээр
(Өссөн дүнгээр, мянган харилцагч)




Олгосон зээлийн тоо, өссөн дүнгээр
(Сая зээл)



Олгосон зээлийн дүн, өссөн дүнгээр
(Тэрбум төгрөг)



Цэвэр зээлийн багц
(Тэрбум төгрөг)



04

Санхүүгийн үйл ажиллагаа



Санхүүгийн байдлын хураангуй тайлан

Компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2020 оны 1-р улиралд 62.6 тэрбум төгрөгт хүрч 2019 оны жилийн эцсээс 4.5 тэрбум төгрөгөөр буюу 7.8%-иар, өмнөх оны мөн үеэс 29.2 тэрбум төгрөгөөр буюу 87.3%-иар тус тус өссөн байна.

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2019.IV	2020.I
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2.4	6.6
Зээлийн багц(цэврээр)	49.5	50.4
Бусад хөрөнгө	4.8	4.1
Үндсэн хөрөнгө	1.2	1.3
Биет бус хөрөнгө	0.3	0.2
Нийт хөрөнгө	58.1	62.6

Өр төлбөр /Тэрбум төгрөг/	2019.IV	2020.I
Эх үүсвэр	38.0	40.5
Хуримтлагдсан хүүгийн өглөг	0.6	0.7
Хэтэвчийн үлдэгдэл	1.0	0.9
Бусад өглөг	1.4	2.8
Нийт өр төлбөр	40.9	44.9

Эздийн өмч /Тэрбум төгрөг/	2019.IV	2020.I
Хувьцаат капитал	10.5	10.5
Тухайн жилийн ашиг	4.9	1.7
Хуримтлагдсан ашиг	1.7	5.5
Эздийн өмчийн дүн	17.2	17.7
Нийт өр төлбөр болон эздийн өмч	58.1	62.6

Зээлийн багцын үзүүлэлтүүд

2020 оны 1-р улирлын байдлаар чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 3.0% болж, эрсдэлийн сангийн хүрэлцээ 131.3% болж өссөн үзүүлэлтэй байна.

Тэрбум төгрөг	2019.IV	2020.I
Нийт зээлийн багц	51.0	52.5
Хэвийн зээл	48.2	50.3
Хугацаа хэтэрсэн зээл	1.0	0.6
Чанаргүй зээл	1.8	1.6
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	3.5%	3.0%
Зээлийн эрсдэлийн сан	(1.6)	(2.1)
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	88.9%	131.3%

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

ЛэндМН ББСБ ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллаж ирсэн билээ. Компанийн зохистой харьцааны үзүүлэлтүүд 2020 оны 1-р улиралд дараах байдалтай байна.

Зохистой үзүүлэлт	Байвал зохих	2019.IV	2020.I
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	26.0%	29.2%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	26.0%	29.2%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	29.6%	28.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	17.8%	15.8%
Хөрөнгө /Актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (%)	100%	199.9%	210.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-5.3%	-8.3%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	79.7%	78.7%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	20.5%	25.0%

05

Компанийн засаглал



Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2020 оны I улиралд ээлжит 1, ээлжит бус 2 удаа хуралдаж 12 тогтоол гаргалаа. ТУЗ-өөс гаргасан тогтоолуудаас дурдвал:

- “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК-ийн гаргасан 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Компанийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн ба тус тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхээр тогтов.
- Компани 2019 оны жилийн эцсийн байдлаар 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба цэвэр ашгийн 24.44% -тай тэнцэх, 1.2 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 1.50 төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэв. Ногдол ашгийг 2020 оны 2 сарын 25-ны бүртгэлийн өдрөөр бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигч нарт 2020 оны 4 сарын 30-ны өдөр дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан олгохоор боллоо.
- Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, эх үүсвэрийн төлөвлөгөөг баталлаа.
- Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 5 тэрбум хүртэл төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх саналыг Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхээр тогтлоо.
- “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар тогтож, шийдвэрлүүлэхээр боллоо.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зарлан хуралдуулахаар шийдвэрлэж, хурлаар хэлэлцүүлэх асуудал, хурал зохион байгуулах болон тооллогын комиссын бүрэлдэхүүн зэргийг батлав. COVID19 вирусийн тархалттай холбогдуулан зарласан гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр хийхээр шийдвэрлэв.
- Дотоод аудитын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Компанийн дотоод аудиторoor М.Оюун-Эрдэнийг томилов.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүгнэлтүүд

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хурлаараа 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэхтэй холбоотой зарим асуудлыг хэлэлцэж, холбогдох дүгнэлт гаргав. Тухайлбал:

- Компанийн Гүйцэтгэх удирдлагын зүгээс гаргасан ЛэндМН ББСБ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг улируулах сонгох саналыг үндэслэн, 2019 оны ТУЗ-ийн хурлын ирц, оролцоо, үр дүн зэргийг хэлэлцэн, ТУЗ-ийн ердийн 5, хараат бус 3 гишүүнийг улируулан сонгох асуудлаар холбогдох дүгнэлт гаргаж, саналыг ТУЗ-д танилцуулан, Хувьцаа эзэмшигчдийн хуралд шийдвэрлүүлэхээр тогтлоо.
- Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн Мэтью Вэлчийн бүрэн эрхийг өөрийнх нь хүсэлтийн дагуу 2019 оны 8 сарын 15-ны өдрөөр дуусгавар болгосонтой холбогдуулан ЛэндМН ББСБ ХК-ийн энгийн хувьцааны 75 хувийг эзэмшигч Анд системс ХХК-аас тус Компанийн Гүйцэтгэх захирал Цэвэгжавын Одмаг ердийн гишүүнд нэр дэвшүүлэх санал ирүүлснийг хэлэлцэн, холбогдох шаардлагыг бүрэн хангасан тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр дүгнэлт гаргалаа.
- ТУЗ-ийн 2020 оны төсөв болон Гүйцэтгэх захирлын 2019 оны гүйцэтгэлийн талаар холбогдох дүгнэлтүүдийг гарган, ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд холбогдох саналыг оруулахаар шийдвэрлэв.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хурлаараа дараах асуудлыг хэлэлцэн, холбогдох дүгнэлт гарган, ТУЗ-ийн хуралд танилцуулж, холбогдох асуудлыг шийдвэрлүүлэв.

- Компанийн эрсдэлийн 2019 оны тайлан;
- Эх үүсвэрийн 2020 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, ТУЗ-өөр батлуулахаар холбогдох дүгнэлт гаргав.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2020 оны I улиралд ээлжит болон ээлжит бус 2 удаагийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн, холбогдох дүгнэлт гарган, ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэв.

- 2019 оны компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- Компанийн дотоод аудиторыг сонгон шалгаруулж, томилох зэрэг дүгнэлтүүдийг гарган ажиллалаа.

2020-2021 онд ажиллах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар томилогдсон ТУЗ-ийн гишүүд



ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

АНД Системс ХХК
Үйл ажиллагаа хариуцсан захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

О.БОЛДБААТАР

ЛэндМН ББСБ ХК
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

В.БАЯРСАЙХАН

АНД Глобал
Үйл ажиллагаа хариуцсан захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

Н.ЦЭВЭГМИД

Мирэ Эссет Секьюритис Монгол
ҮЦК ХХК Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

С.ЭНХ-АМГАЛАН

Петровис ойл ХХК
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

Ц.ОДМАА

“Анд Системс” ХХК
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ч.НОМИН

Монгол телевиз ХХК
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн

С.БОРГИЛ

Сэргэлт Консалтинг Групп
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ж.ЖАРГАЛСҮРЭН

Далайван аудит ХХК
Гүйцэтгэх захирал



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn